



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/708

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 77 дугаар зөвлөмжийн дагуу Төгрөг сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер (ӨВАОНӨГ/201810056)-ийг 179100508 (нэг зуун далан есөн сая нэг зуун мянга таван зуун найм) төгрөгөөр “Гуа-Орд” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101545

D:My Doc. Zahiramj. Zasag darga